

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАРИМ АЛБАН ТУШААЛТНЫГ ТОМИЛОХТОЙ ХОЛБООТОЙ БҮРЭН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

О.Нарантуяа

Улсын Их Хурлын дарга нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан 22 бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд үүний дотор зарим байгууллагын удирдлагыг томилох, санал болгох бүрэн эрхтэй.

Холбогдох 8 хуульд зааснаар УИХ дарга нь 7 байгууллагын удирдах албан тушаалтанд томилуулахаар санал болгож, тэднийг УИХ томилж, чөлөөлж байна. Ирээдүйн өв сангийн тухай хуульд зааснаар Хяналтын зөвлөлд өөрийн сонгосон хүнээ мөн санал болгоно.

УИХ дарга нь өөрийн зөвлөхүүдийг томилж байна.



	Хуулийн нэр	Зохицуулалтын агуулга
1	Төв банкны тухай хууль	26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага 1. ... Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.
2	Улсын Их Хурлын тухай хууль	11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрх 11.1.21.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх; 40 дүгээр зүйл. Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга 40.1. Тамгын газрыг хууль зүй, улс төрийн өндөр мэргэшил бүхий Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө.
3	Төрийн аудитын тухай хууль	13 дугаар зүйл.Ерөнхий аудитор 13.1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно.
4	Хүний эрхийн үндэсний комиссын тухай	13 дугаар зүйл.Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 13.4.Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.
5	Сонгуулийн төв байгууллагын тухай	4 дүгээр зүйл.Хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журам 4.3.Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно.
6	Статистикийн тухай	13 дугаар зүйл.Үндэсний статистикийн хорооны удирдлага 1.Үндэсний статистикийн хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаагаар томилно.
7	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	11.2.Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, ... нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас томилно.
8	Ирээдүйн өв сангийн тухай	15 дугаар зүйл. Хяналтын зөвлөл 15.5.2.Монгол Улсын Их Хурлын даргын сонгосон санхүү, эдийн засгийн судалгаа, шинжилгээний туршлагатай, нийгэмд үйлчлэх гурав хүртэлх төрийн бус байгууллагаас;